

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Аяагийн Цэрэндорж	Дугаар	L040
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Архангай аймгийн Цэцэрлэг сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарбабандидын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨРА 065
Одоогийн сүм хийд	Төмөр замын хийд	Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Хөвсгөл аймгийн Рашаант сумын Дарбабандидын хүрээ

Манай хүрээ 18 дуган, 5 дацантай, гол шүтээн нь Жамсран байсан. Лхамыг тахидаггүй газар гэж байгаагүй. Баруун дацан, Хойд дацан, Манба, Авга, Гүнрэгийн дацан байсан. Сэрийн игчаатай Чойртой байсан. Тус тусдаа сүмтэй. Манай хүрээ 1000-д ламтай байсан. Манай хүрээ Зая гэгээний дэгтэй юм аа. Ойр хавьд нь шүтлэгтэй гол нь Дулаан хаан уул байсан. Бандид гэгээний хүрээ гэж нэрлэгддэг байсан. Рашаант гэж нэг агуй байсан. Түүгээрээ Рашаантын хүрээ гэж нэрлэгдсэн. Манайх Цагаан уулын овоо, Дүйнхорын овоо, Манбын овоог тахидаг байсан.

Дарва Бандид гэгээн гэж Богдын хүрээнд гайхагдсан лам байлаа. Дарва Бандид гэгээн 17 тодорсон юм гэнэ лээ. Хамгийн сүүлчийн дүр нь Бандид гэгээн Агваанлуvsанчойжидондов гэж өөрийн нь алдар. Чойрын

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

номондоо маш сайн байсан. Бандид цолтой хүн Монголд дөрөвхөн байсан юм байна лээ. Баруун Монголд нэг. Өвөрхангайд Тарган бандид гэгээн гэж байсан.

Би Чойрын дацанд хурж байсан. Манай зиндаа 100 гаруй хүнтэй байсан. Би шиндай соролжид хүртэл ном үзсэн. Зиндааны жорвон болсон. Чойр дацангийн шунлайв нь Дагдан шунлайв гэж байсан. Сэрий игчаатай байсан. Дацан дацандаа нэг нэг ловонтой байсан.

Манай хүрээний ойролцоо Бухын хүрээ, Хялгантын хүрээ гэж байсан. Тэгээд тоолоод байвал жижиг дуганууд олон. Агьтын дуган гэж хоёр модон дугантай газар байсан.

Өдөр тутамд хурал тасрахгүй. Аж гэж хурал хурдаг байсан. Гол нь Ламын чодваар эхэлдэг байсан юм. Цогчэн гэсгүй, унзад нар нэг жилийн хугацаатай байна. Нэг жил болоод л солигдоно. Цогчэн уншлагаа лам нарт 15, 15 хоногоор даалгачихдаг байсан. Том лам нар өөрийнхөө оронд шавь нараа оруулдаг байсан. Шинийн 8-нд Ерөөл л голлоно доо, 15-нд мөн ерөөл, Сэндом, Яши, цацал, 29-нд Арван хангал хурна. Цагаан сараар Дүйнхор, Манба, Гүнрэг, Янсан Ядам хурна. Цагаан сарын битүүнд Цэдор Лхамаа тус тусдаа тахиад сүүлдээ Цогчэн дугандаа бүгдээрээ нийлж Цэдор Лхамаа өргөдөг байсан юм. Сор зална. Хувилгаантай байлаа. Бүр сахиус зална. Тэгээд шинийн нэгнээс 15 хүртэл ерөөл хурна. Дүйчэн өдрүүдээр гол нь Итгэлийг л их олон оруулгатай хурдаг байсан. Богд ламын дүйчэн өдрөөр Богдынхоо том зургийг дэлгэчихээд Ганданлхавжаа хурдаг байсан юм.

Манайд 100 гаран дүртэй цам гардаг байсан. Зуны дунд сарын 14-нд цам гарна. Майдараа зуны сүүл сарын 15-нд эргэнэ. Майдар эргэхэд цам гарна. Майдар эргэхдээ үд хийх гэж дөрвөн газар зогсоно. Тэгээд цам харайна. Дараа нь хайлан залгачихдаг байсан юм. Хайлан 45 хоног хурна. Энэ үед хөдөө гарч болохгүй. Сүмээ харагдах газар явж хурна уу гэхээс өөр газар явж хурахгүй. Сар хиртэхэд Ганжуурын баринтгаа задлахгүй эргэдэг байсан. Манай хүрээн дээр цам, сорын цам хоёр удаа гарна, Майдарын цам нэг гарна. Сорын цам нь Майдарын цамаас бага.

Хийдийн голын Дарь эхийн сүм, Манбын дацан гэсэн хоёр дуганыг модоор, бусдыг нь хөх туйпуугаар барьсан. Монголчууд барьсан.

Манай хүрээн дээр гаднаас ирж гавжийн дамжаа барьдаг байсан. Ойр хавьд манай Багшийн хүрээ шиг гоё хүрээ байгаагүй.

Манай хүрээний дацан бүр жастай. Жас нь малтай. Малын тоог мэдэхгүй.

Юу ч гэсэн жандаггүйгээр хурлаа хуруулж дийлээд байдаг байсан.

1937 онд том тушаалтай лам нарыг бариад явсан, ном судрыг нь устгаад, барилгыг нь нураагаад, шөнө шатаасан. Манай зиндааны Жигжид гэдэг хүн нутагтаа байгаа. Мөн Түвдэнням гэдэг хүн бий. Одоо хотод байгаа. Би хар болоод хоршооны туслах нягтлан бодох хийсэн. 1942 онд хотод ирсэн. Нисэхэд ажиллаж байсан. Лам байсан гээд гадаадад сургуульд явж чадаагүй. Батлан хамгаалах яам, Төмөр замд ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан. Төмөр замын хийд байгуулагдснаас нь хойш энд хурж байна.

Манай Дарбабандид гэгээний хийд сэргээгдсэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА